



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/03.

Улаанбаатар хот

Оролцоог хангах нэгдсэн төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан зээлийн гэрээ болон буцалтгүй тусламжийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах байгууллагуудын оролцоог хангах нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний дагуу хамтарсан хэлэлцүүлэг, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж, холбогдох байгууллагуудын оролцоог хангаж, хэрэгжилтийн үр дүнг Төслийн удирдах хороонд жил бүр танилцуулж байхыг Төслийн зохицуулагч 3.Мөнхзулд даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төслийн захирал С.Тунгалагтамирт үүрэг болгосугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



151200002



**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэг. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхийг бэхжүүлэх, институтчлэх үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, оролцоог хангах хүрээнд:

	Оролцогч талууд	Чиг үүрэг, хэрэгцээ шаардлага	Оролцооны арга, түвшин	Хамтын ажиллагааны хэлбэр	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.	ХБХ-ийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс (ЭМБНХК)	ЭМБНХК нь 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй бөгөөд Хүүхдийн хөгжлийн үе шатны асуумж ба “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ –III” –ийн талаар аймаг, дүүргийн сум, хороодод сургалт зохион байгуулах мэргэжил, арга зүйгээр хангаж байна.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хамтарсан хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үнэлгээ болон асуумжийн загвар боловсруулах, хэрэглэх талаар санал хүсэлт өгөх, санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх	ЭМЯ, ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар
2.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)	ЭХЭМҮТ нь шинэ төрсөн хүүхдүүдэд оношилгоо хийж, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чиг үүрэгтэй.	Зөвлөгөөн (дунд зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, төслийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хуваалцах, хэлэлцэх	ЭМЯ, ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар

		ЭХЭМҮТ-ийн эмч, эрдэмтэн, судлаач нар “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ – III” (BSID-III)-г хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэхэд ашиглаж байна.		Зөвлөгөөн: Төслийн үр дүнгийн талаар хэлэлцэх, санал хүсэлт ирүүлэх Хэрэгжилт: “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ-III” ба Хүүхдийн хөгжлийн үе шатны асуумж (ASQ) боловсруулах, туршилтыг хийхэд дэмжлэг үзүүлэх		
3.	Гэмтэл согог судлалын үндэсний төв (ГССҮТ)	ГССҮТ-ийн эмч нар гэмтлийн улмаас үүссэн хөгжлийн бэрхшээлийг оношилдог бөгөөд цаашид “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ – III”-ийн талаар ойлголттой болж, тус аргачлалыг үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай.	Зөвлөгөөн (бага зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, сургалтад оролцон, төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Зөвлөгөөн: “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ”-III аргачлалыг туршиход эмч нарыг оролцуулах, тэднээр хэлэлцүүлэн саналыг ирүүлэх	ЭМЯ, ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар
4.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нар хүүхдийн оюуны хөгжлийн бэрхшээлийг оношилж байна. Цаашдаа “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ–III” аргачлалыг хүүхдийн оюуны хөгжлийн бэрхшээлийг оношлоход ашиглах шаардлагатай.	Зөвлөгөөн (бага зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, сургалтад оролцож, төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Зөвлөгөөн: “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ”-III аргачлалыг туршиход эмч нарыг оролцуулах, тэднээр хэлэлцүүлэн саналыг ирүүлэх	ЭМЯ, ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар
5.	Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)	Хөгжлийн бэрхшээлийн талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх тогтолцоог сайжруулахад Вашингтон Группийн арга зүйг ашиглаж эрт илрүүлэлтийн	Мэдээлэл солилцоо (бага зэрэг)	Мэдээлэл: ХНХЯ болон ЭМЯ, бусад холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хурал, уулзалт зохион байгуулах замаар хөгжлийн бэрхшээлийн өнөөгийн	ЭМЯ ХНХЯ, ҮСХ, ТХН	2020 оны 03-р сар - 2020 оны 09-р сар

		судалгааны загварыг боловсруулахад хамтран ажиллах шаардлагатай.		статистик, түүнийг боловсронгуй болгох талаар хэлэлцэх		
6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ)	Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх загварыг институтчилэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг чиг үүрэгтэй ажиллана.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хамтарсан хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үнэлгээ, загварыг хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах	ХНХЯ, ТХН, ХБХХЕГ	2019 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв (ХБХСЗХТ)	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх оношилгоо, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн хамт сэргээн засах эмчилгээ, сургалтад хамруулах зэрэг цогц үйлчилгээг хүргэж ажилладаг.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, төслийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Хэрэгжилт: “Нялхас бага насны хүүхдийн хөгжлийн Бейли үнэлгээ-III” ба Хүүхдийн хөгжлийн үе шатны асуумж (ASQ)-ийг ашиглах талаар сургалтад хамрагдах, арга зүйг үйл ажиллагаандаа ашиглах	ХНХЯ, ТХН, ХБХСЗХТ	2019 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
8.	Эцэг эхчүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд	Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, эмчлэх үйл ажиллагаа эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх ажлын туршлагатай байдаг. ХБХ-ийн эцэг эхчүүд нь тус үйл ажиллагааны нөлөөлөлд шууд хамаарах бүлэг юм.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, фокус бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож, төслийн талаар мэдээлэл хуваалцах, хэлэлцэх Зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үнэлгээ болон асуумжийн загвар боловсруулах, хэрэглэх талаар	ЭМЯ, ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар

				санал хүсэлт ирүүлэх, санал дүгнэлт, зөвлөмж өгөх		
9.	Иргэний нийгмийн байгууллагууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийн төлөөх Иргэний нийгмийн байгууллагууд болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд тус төслийн үр шим хүртэгч бүлгүүдийн ашиг сонирхлыг төлөөлнө.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Хяналт, үнэлгээ: Техникийн ажлын хэсэг, сонгон шалгаруулалтын үнэлгээний зөвлөлд оролцон, хамтарсан хяналт тавих, төслийн үйл явцыг хянах Хэрэгжилт: Мэргэжлийн ур чадвар олгох сургалт зохион байгуулах, хамтран чадавхижуулах, нөлөөллийн болон ойлголт хандлага дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах	ХНХЯ, ТХН	2018 оны 09-р сар - 2022 оны 12-р сар

Төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулах үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, оролцоог хангах хүрээнд:

	Оролцох байгууллагууд	Чиг үүрэг, хэрэгцээ, шаардлага	Оролцооны арга, түвшин	Хамтын ажиллагааны хэлбэр	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.	Аймаг, дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл	Аймаг, дүүргийн Нийгмийн бодлогын хэлтэс нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй. Салбар комиссууд нь туслан зохицуулах, чадавхижуулах ба хяналт тавих үүрэгтэй оролцоно.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Хурал, уулзалт, семинар зохион байгуулж, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёлын болон Эрүүл мэндийн газар, Салбар комиссын үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл хүргэх, чадавхижуулах сургалт зохион байгуулах	ТХН, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, Салбар комисс	2018 оны 06-р сар - 2022 оны 12-р сар

	мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс	Эцэг эх – хүүхэд – үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоо, дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр бүх шатны боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамрагдах учир төрийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа нэн чухал шаардлагатай.				
2.	Сонгогдсон аймгуудын Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах аймаг, дүүргийн орон тооны бус салбар зөвлөл	Сонгогдсон аймгуудын Засаг даргын Тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн төвийг байгуулж, ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ. Эдгээр аймагт ТХН-ийн удирдлагад төслийн дэд зохицуулагч ажиллана. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь дэд зохицуулагч үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлж, хамтран ажиллана.	Хамтын ажиллагаа/ түншлэл (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Хурал, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, ЗДТГ-уудын туслан зохицуулалтын талаар тогтмол мэдээлэл хүргэх, салбар зөвлөлүүдээс хөгжлийн төвийн үйл ажиллагааны удирдамж боловсруулахад саналыг авч тусгах, хэлэлцэх, зөвлөлдөх	ХНХЯ, ТХН, сонгогдсон аймгуудын Засаг даргын тамгын газрууд, Салбар зөвлөлүүд	2019 оны 06-р сар - 2022 оны 12-р сар
3.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ) Анагаахын шинжлэх ухааны их сургууль (АШУИС), Монгол Улсын Боловсролын их	БСШУСЯ, АШУИС, МУБИС нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэдэг. Цаашид дээр байгууллагууд нь хөдөлмөр, хэл яриа засал, сэргээн засах эмчилгээ болон нийгмийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тусган баталж, нэвтрүүлэх ажлыг хариуцна.	Хамтын ажиллагаа (бага зэрэг)	Зөвлөгөөн: БСШУСЯ, АШУИС ба МУБИС нь ХНХЯ-тай хамтарсан хурал уулзалт, ярилцлага хийх хэлбэрээр сургалтын хөтөлбөр боловсруулахад санал зөвлөмж өгөх, хамтарч ажиллах, санал дүгнэлт өгөх Хэрэгжилт: Сургагч багш нарт зориулсан семинар, сургалтуудыг зохион байгуулах Хяналт, үнэлгээ: Сургалтын хөтөлбөрийг хянах, үнэлэх, дүгнэлт өгөх	ХНХЯ, БСШУСЯ, АУИС, БИС, МСҮТ, ТХН	2019 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

	сургууль (МУБИС)	Түүнчлэн бусад их, дээд сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын сургагч багш нарыг чадавхижуулах ажлыг зохион байгуулна.				
4.	Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газар (ХХМТГ)	ХХМТГ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан лавлах утасны үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	Мэдээлэл солилцоо (бага зэрэг)	Зөвлөгөөн: Лавлах утасны үйлчилгээнд шаардагдах техникийн нөхцөлийг боловсруулах зорилгоор зөвлөгөөн, хурал, уулзалт зохион байгуулах, хэлэлцэх, санал хүсэлт хүлээн авах, дүгнэлт, зөвлөмж өгөх	ХНХЯ, ХХМТГ, ТХН	2020 оны 01-р сар - 2022 оны 12-р сар
4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулах, нийгмийн ажилтнуудыг чадавхижуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зөвлөгөөн, хурал, уулзалт, нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулах	ХНХЯ, ХБХХЕГ, ТХН	2019 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд (ХБИБ)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд бэрхшээлийн төрөл болон үйл ажиллагааны чиглэлээр төрөлжиж ажилладаг. Иймд хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрийн онцлогт тохирсон үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах зэрэг чиглэлээр хамтран ажиллана.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, томилолтын ажилд тогтмол оролцох замаар мэдээлэл солилцох, хэлэлцэх Хяналт, үнэлгээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо болон техникийн ажлын хэсэгт оролцож, явцын хяналт үнэлгээний ажилд оролцох	ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, ТХН	2018 оны 11-р сар - 2022 оны 12-р сар

6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төслийн үндсэн үр шим хүртэгч бүлгийн хувьд өөрсдийн хэрэгцээ шаардлагыг төслийн үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор мэдээлэл, зөвлөгөө санал хүсэлтээ хуваалцана.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааны удирдамж боловсруулахад санал зөвлөмж өгөх, хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулах Зөвлөгөөн: Танилцуулга, сурталчилгааны ажилд оролцох, зөвлөлдөх, санал хүсэлтээ ирүүлэх	ХНХЯ, ТХН, Туслан зохицуулагчид	2018 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
----	----------------------------	---	-------------------------	---	---------------------------------	---------------------------------------

Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг. Орчны хүртээмжийг сайжруулах үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, оролцоог хангах хүрээнд:

	Оролцох байгууллагууд	Зорилго, хэрэгцээ, шалтгаан	Оролцооны арга, түвшин	Хамтын ажиллагааны хэлбэр	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.	Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), Зам тээвэр хөгжлийн яам (ЗТХЯ), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)	БХБЯ, ЗТХЯ, ХХМТГ нь дэд бүтэц, зам тээвэр ба мэдээллийн хүртээмжтэй холбоотой бодлого, дүрэм журам, стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. ГЗБГЗЗГ нь газар, хот төлөвлөлттэй холбоотойгоор Засгийн газраас баримталж буй бодлого, стандартыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг хариуцдаг. Цаашид барилга байгууламж, зам тээвэр болон мэдээллийн хүртээмжийн эрхзүйн орчинг сайжруулах удирдамж, стандарт боловсруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд хийх	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Хамтарсан хурал, уулзалт, чадавхижуулах сургалт ба семинар зохион байгуулж, хүртээмжтэй холбогдох дүрэм журам, стандартыг сайжруулах талаар зөвлөлдөх, санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, шийдвэрт тусган батлуулах	БХБЯ, ЗТХЯ, ХНХЯ, ХХМТГ, ГЗБГЗЗГ, ТХН,	2018 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

		өөрчлөлтийг тодорхойлон стандарт, дүрэм журамд тусган батлуулахад хамтарч ажиллана.				
2.	Стандарт хэмжил зүйн газар (СХЗГ) Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) Барилга хүлээн авах улсын комисс (БХАУК)	СХЗГ нь стандарт боловсруулах чиг үүрэгтэйгээр ажилладаг. МХГ нь бодлого, дүрэм журам болон стандартын хэрэгжилтийг хариуцаж ажиллана. ББҮУК нь барилга байгууламжийн ашиглалтад үнэлгээ хийх чиг үүрэг бүхий байгууллага юм. Цаашид СХЗГ-тай барилга, дэд бүтэц, зам тээврийн хүртээмжтэй холбоотой стандартыг шинэчлэхэд хамтарч ажиллана. МХЕГ болон БХАУК-той хамтран холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийх, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтарч ажиллана.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Хамтарсан хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, загвар боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, сайжруулах өөрчлөлтийг стандарт, дүрэм журамд тусган батлуулах	ХНХЯ, СХЗГ, МХЕГ, ББҮУК, ТХН	2018 оны 03-р сар - 2022 оны 12-р сар
3.	Барилгын хөгжлийн төв (БХТ) Зам тээврийн хөгжлийн төв (ЗТХТ)	БХТ нь Засгийн газраас баримтлах барилга байгууламжтай холбоотой бодлого, норм, стандартыг хэрэгжүүлж ажилладаг ба архитектор, барилга төлөвлөгчдөд зориулсан сургалтыг зохион байгуулдаг. ЗТХТ нь автозам, тээвэртэй холбоотой бодлого, хяналтыг хэрэгжүүлэх, зам тээврийн стандарт, норм нормативын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Хамтарсан хурал, уулзалт, семинар, ярилцлагад оролцож, бодлого, стандарт, норм нормативын загвар боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, сайжруулах өөрчлөлтийг стандарт, дүрэм журамд тусган батлуулах	БХТ, ХНХЯ, ЗТХТ, ТХН	2019 оны 12-р сар - 2022 оны 12-р сар

		Төслийн хүрээнд цаашид барилга, дэд бүтэц, зам тээврийн хүртээмжтэй холбоотой стандартыг шинэчлэхэд БХТ болон ЗТХТ-тэй хамтарч ажиллана.				
4.	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөл (ХБХЭХСЗ)	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь аймаг, нийслэл, дүүргүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц, мэдээллийг бий болгох, холбогдох стандартыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Салбар зөвлөлүүд төслийн холбогдох үйл ажиллагааг орон нутагтаа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.	Зөвлөгөөн (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Хүртээмжийн норм, стандартын талаарх ойлголт, чадавхийг шийдвэр гаргагчдад олгох зорилгоор мэдээлэл солилцооны хурал уулзалт, хамтарсан семинар, сургалт зохион байгуулах Хяналт: Төслийн хэрэгжилтийн үйл явцыг хянах зорилгоор улирал тутмын үйл ажиллагааны хяналтын хурал зохион байгуулах Мэдээлэл, санал, гомдол: Барилгын ажил эхлэхээс өмнө, аймаг тус бүр төслийн талаарх санал хүсэлт хүлээн авах нэгжийг байгуулж, төслийн хэрэгжилтийн туршид нөлөөлөлд өртсөн хүмүүсээс санал хүсэлт, гомдлыг хүлээн авах	ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрууд, ТХН, туслан зохицуулагчид, аймаг, нийслэл, дүүргийн ХБХЭХСЗ	2018 оны 03-р сар - 2022 оны 12-р сар
5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХЕГ)	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг чиг үүрэгтэй ажилладаг.	Мэдээлэл солилцоо (өндөр зэрэг)	Мэдээлэл: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, мэдээлэл солилцох, санал хүсэлт, дүгнэлт, зөвлөмж ирүүлэх Хяналт: Хүртээмжийн хэрэгжилтэд хяналт хийх	ХНХЯ, ХБХЕГ, ТХН	2019 оны 01-р сар - 2022 оны 12-р сар

		Цаашид орчны хүртээмжийг сайжруулах мэдээлэл, зөвлөгөөний арга хэмжээг зохион байгуулалтаар хангах, сурталчлах таниулах, хүртээмжийн хэрэгжилтэд хяналт тавихад хамтарч ажиллана.				
6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага	МХҮХ, Түгээмэл хөгжил төв, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн хүртээмжийн байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх шийдвэр гаргагчдад нөлөөлөх, хувийн хэвшлийн байгууллагууд холбогдох журам, стандартыг хэрэгжүүлэх, тэдний хандлагыг өөрчлөхөд нөлөөлдөг. Цаашид хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрийн онцлогт тохирсон үйл ажиллагааг төлөвлөх, үнэлгээний ажилд оролцуулах чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Зөвлөгөөн, хурал, уулзалт зохион байгуулж, сонсгол, хараа, бие хөдөлгөөн, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй санал солилцох, тэдний гаргасан бодлогын баримт бичиг, дүрэм журам, стандартад оруулах тодорхой санал зөвлөмжийг ирүүлэх Хэрэгжилт: Мэргэжлийн ур чадварын сургалтад хамрагдах, ХНХЯ-тай хамтран сургалт, семинар болон нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах Үнэлгээ: Хүртээмжийн үнэлгээний ажилд оролцох, үнэлэх, санал дүгнэлт ирүүлэх	ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, ТХН	2018 оны 11-р сар - 2022 оны 12-р сар
7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)	ХБИ нь энэ төслийн үндсэн үр шим хүртэгч бүлэг бөгөөд төслийн үйл ажиллагааг тэдний хэрэгцээ шаардлагатай уялдуулж нийцүүлэх зорилгоор тэднээс санал, зөвлөмжийг авах шаардлагатай.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Мэдээлэл: Хурал, уулзалт, томилолтын ажилд тогтмол оролцох замаар мэдээлэл солилцох, хэлэлцэх Зөвлөгөөн: Танилцуулга, сурталчилгааны ажилд оролцох, зөвлөлдөх, санал хүсэлтээ ирүүлэх	ХНХЯ, ТХН, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	2018 оны 12-р сар - 2022 оны 12-р сар

Төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, оролцоог хангах хүрээнд:

	Оролцох байгууллагууд	Зорилго, хэрэгцээ, шалтгаан	Оролцооны арга, түвшин	Хамтын ажиллагааны хэлбэр	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл	<p>Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг удирдамж чиглэлээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.</p> <p>Салбар зөвлөлүүд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн төсвийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлан, үнэлгээг хэлэлцэн санал дүгнэлт гаргах, хөтөлбөр төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн Үндэсний зөвлөлд хүргүүлдэг.</p> <p>Төслийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь ХБИ-дэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах, олон нийтэд сурталчлах зэрэг</p>	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	<p>Мэдээлэл, зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох хурал, уулзалт, хамтарсан семинар сургалтуудыг зохион байгуулах</p> <p>Хяналт: Төслийн хэрэгжилтийн явцыг хянах зорилгоор хяналтын хурал хийх</p>	ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд, салбар зөвлөлүүд, ТХН, туслан зохицуулагч нар	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

		ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.				
2.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), Аймаг, дүүргийн ХХҮГ/ ХХҮХэлтсүүд	ХХҮЕГ нь аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудыг бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна. Аймаг, дүүргийн ХХҮГ/ ХХҮХэлтсүүд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, сум, хорооны нийгмийн ажилтнуудыг удирдамж чиглэлээр хангах ажиллах үүрэгтэй. ХХҮЕГ нь ХБИ-дэд хөдөлмөр эрхлэлтийн кейс менежментийг хэрэгжүүлэх удирдамж чиглэлийг боловсруулах, нэгдсэн удирдлагаар хангах, аймаг, дүүргийн ХХҮГ/Хэлтсүүд нь ХБИ-дэд зориулсан кейс менежментийн аргачлалыг хэрэгжүүлж ажиллана.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэх, ХБИ-ийн ажлын байрыг дэмжих бодлого, арга хэмжээг сайжруулах санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх Хэрэгжилт: Сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтнуудад чадавхижуулах сургалт зохион байгуулах, кейс менежментийг хөгжүүлэх ажлыг зохион багуулах	ХНХЯ, ХХҮЕГ, ТХН	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (ХБХХЕГ)	ХБХХЕГ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зарим үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, ажлын байранд дадлагажуулах сургалт зохион байгуулах, хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлэх зэргээр тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Цаашид ХБИ-ийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ХБИ-дэд үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.	Мэдээлэл солилцоо (бага зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, мэдээлэл солилцох, санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, сургалт зохион байгуулах	ХНХЯ, ХБХЕГ, ТХН	2019 оны 01-р сар - 2022 оны 12-р сар
4.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг жил бүр хийж байна. ХНХЯ-ны захиалгаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд олгох ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт зэрэг судалгаа хийсэн. Төслийн хүрээнд цаашид ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, ур чадварын судалгаа,	Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)	Мэдээлэл: Хөдөлмөрийн зах зээл, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ур чадварын хэрэгцээ болон ажлын байрны квотын судалгааны талаар мэдээлэл солилцох хурал уулзалтыг зохион байгуулах, санал дүгнэлт, зөвлөмж өгөх	ХНХЯ, ХНХСИ, ТХН	2019 оны 06 сар - 2022 оны 06 сар

		хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, квотын судалгаа зэрэг судалгааг хийхэд хамтарч ажиллана.				
5.	Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсүүд (Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд) Хөдөлмөрийн хувийн биржүүд	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд хуулийн дагуу ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, ажлын байранд зуучлах, мэдээлэл, зөвлөгөө өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна. Хөдөлмөрийн бирж нь ажил хайгч иргэдийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулдаг. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд, Хөдөлмөрийн хувийн биржүүд нь цаашид ХБИ-дэд чиглэсэн шинэ үйлчилгээ, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагааг орон нутагт нэвтрүүлж, зохион байгуулна.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээлэл хүргэх, ХБИ-ийн ур чадварыг дээшлүүлэх, ажилд зуучлах шинэ үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, чадавхийг бэхжүүлэх сургалтад хамрагдах	ХНХЯ, ХХҮЕГ, Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд, Хөдөлмөрийн хувийн биржүүд	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар
6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд (ХБИБ)	ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаарх хууль тогтоомжийг боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.	Зөвлөгөөн (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Зөвлөгөөн, хурал, уулзалтад оролцож, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ажлын байрны нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар санал солилцох, санал хүсэлт, зөвлөмжийг ирүүлэх	ХНХЯ, ХБИБ, ТХН	2018 оны 11-р сар - 2022 оны 12-р сар

		Төрийн бус байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ХБИ-ийн онцлогт тохирсон ажлын байр бий болгох, сургалт явуулах зэргээр оролцдог. Мөн ажил олгогчидтой тохируулгатай ажлын байрыг бий болгох, Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн асуудлаар зөвлөгөө өгөх зэргээр хамтран ажиллаж байна. Цаашид холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихад зөвлөгөө өгөх, ХБИ-ийн ажлын байр, хувиараа хөдөлмөр эрхлэх болон оролцоотой бизнесийг хөгжүүлэхэд хамтарч ажиллана.		Хэрэгжилт: Мэргэжлийн ур чадварын сургалтад хамрагдах, ХНХЯ-тай хамтран семинар, сургалт болон нөлөөллийн үйл ажиллагаа явуулах Хяналт: Сонгон шалгаруулалтын үнэлгээний комиссын ажилд оролцох, хяналт тавих		
7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)	ХБИ нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, үйл ажиллагаанаас үр шим хүртэх гол бүлэг юм.	Зөвлөгөөн (дунд зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох хурал, уулзалт, хамтарсан семинар, сургалтад оролцох, санал хүсэлтээ ирүүлэх, дүгнэлт зөвлөмж өгөх	ХНХЯ, ХБИ, ТХН, туслан зохицуулагч нар	2018 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
8.	Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (АОЭНХ), Худалдаа аж үйлдвэрийн танхим (ХАҮТ),	АОЭНХ, ХАҮТ болон мэргэжлийн холбоодыг хамруулсан ИНБ-ууд нь хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллээр ажил олгогчдыг хангах, сурталчлах, хуульд заасан ХБИ-ийн ажлын байрны	Мэдээлэл солилцоо (өндөр зэрэг)	Мэдээлэл: ХБИ-ийг ажлын байраар хангах талаар ажил олгогчдод мэдээлэл хүргэх, сурталчлах арга хэмжээ зохион байгуулах, ажил олгогчидтой хамтарч ажиллах	ХНХЯ, ТХН, АОЭНХ, ХАҮТ, Мэргэжлийн холбоод, ИНБ-ууд	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

	Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ-ууд)	квотын хэрэгжилтийг дэмжиж ажиллана. ХБИ-дэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн квотын системийг шинэчлэхэд санал зөвлөмж ирүүлэх, ХБИ-дийн онцлогт нийцсэн ажлын байраар хангах ажлыг хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.		Хяналт: Хуульд заасан ХБИ-ийн ажлын байрны квотын хэрэгжилтийг дэмжиж ажиллах		
9.	Хувийн хэвшил/ Бизнес эрхлэгчид	Хувийн хэвшлийн байгууллагууд нь хууль тогтоомжийн хүрээнд ХБИ-ийг ажлын байраар хангах, онцлогт нь нийцсэн ажлын байрыг бий болгох үүрэгтэй. ХБИ-дэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн квотын системийг шинэчлэхэд санал зөвлөмж ирүүлэх, ХБИ-дийн онцлогт нийцсэн ажлын байраар хангах ажлыг хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Хамтын ажиллагаа (өндөр зэрэг)	Мэдээлэл: ХБИ-ийн ажлын байрны хэрэгцээг тодорхойлох, тохирсон ажлын байраар хангахад хамтарч ажиллах талаар мэдээлэл солилцох хурал, уулзалт, хамтарсан семинар, сургалтад оролцох, санал хүсэлтээ ирүүлэх, дүгнэлт зөвлөмж өгөх Хяналт: Хуульд заасан ХБИ-ийн ажлын байрны квотын хэрэгжилтийг дэмжиж ажиллах	ХНХЯ, ТХН, АОЭНХ, ХАҮТ, аж ахуйн нэгж, байгууллагууд	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар

Төслийн 5 дугаар бүрэлдэхүүн хэсэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамтын ажиллагаа, оролцоог хангах хүрээнд:

	Оролцох байгууллагууд	Зорилго, хэрэгцээ, шалтгаан	Оролцооны арга, түвшин	Хамтын ажиллагааны хэлбэр	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
1.	Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)	ҮСХ нь улсын хэмжээнд хүн амын тооллого, статистик мэдээллийг цуглуулах, шинжлэх, тооцох, мэдээлэх, түгээх чиг үүргийг хариуцдаг	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: ҮСХ нь ХНХЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтарсан хурал, уулзалт, фокус бүлгийн хэлэлцүүлэг болон хамтарсан семинаруудыг зохион	ХНХЯ, ҮСХ, ТХН	2020 оны 03-р сар - 2020 оны 09-р сар

		Засгийн газрын хэрэгжүүлэгч гол агентлаг юм. ҮСХ-ны хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл цуглуулан шинжлэн тооцож байгаа одоогийн тогтолцоо, судалгаа, арга зүйд хөгжлийн бэрхшээлийн олон улсын үйлдлийн ангилал /ICF/ болон олон улсын бусад арга зүйг нэвтрүүлж, ХБИ-д чиглэсэн бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах шаардлагатай байна.		байгуулах, хөгжлийн бэрхшээлийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх, түүнчлэн бодлого, үйл ажиллагаанд ашиглахад хамтарч ажиллах, санал дүгнэлт өгөх		
2.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)	ХХҮЕГ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг иргэдэд хүргэхэд чиглэсэн мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хөрөнгийг хуваарилах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна. Цаашид ХБИ-ийн нийгмийн халамжийг оновчтой болгох, сайжруулах санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах, халамжийн тусламж, үйлчилгээг хүргэж ажилладаг сум, хорооны нийгмийн халамжийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулна.	Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Ярилцлага, семинар болон сургалтуудыг зохион байгуулах, ХБИ-ийн халамжийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл хүргэх, ХБИ-ийн нийгмийн халамжийг оновчтой болгох, сайжруулах санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх Хэрэгжилт: Сум, хорооны нийгмийн халамжийн асуудал хариуцсан ажилтнуудад чадавхижуулах сургалт зохион байгуулах	ХНХЯ, ХХҮЕГ, ТХН	2019 оны 06 сар - 2020 оны 12-р сар

3.	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ)</p>	<p>НДЕГ нь нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдад эрсдэлд орсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.</p> <p>ЭМДЕГ нь бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, ХБИ-д хууль тогтоомжийн дагуу эмийн хөнгөлөлтийг олгож, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж байна.</p> <p>Цаашид асран хамгаалагчдад олгох тэтгэмжийг оновчтой тогтоох аргачлалыг нэвтрүүлэх, ХБИ-тэй иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, туслах хэрэгслийн хүртээмжийг сайжруулах, нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах зэргээр хамтран ажиллана.</p>	<p>Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)</p>	<p>Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, ХБИ-ийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хэрэгцээт туслах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах</p>	<p>ХНХЯ, ЭМЯ, НДЕГ, ЭМДЕГ, ТХН</p>	<p>2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар</p>
4.	<p>Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв (СЗСҮТ)</p>	<p>СЗСҮТ нь ХБИ-ийн хэрэгцээт туслах хэрэгсэл, протез ортопед үйлдвэрлэх, засварлах, сэргээн засах үйлчилгээ, мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй.</p>	<p>Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)</p>	<p>Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, ХБИ-ийн хэрэгцээт туслах хэрэгсэл, протез ортопедийн хүртээмжийг сайжруулах, засварлах үйлчилгээг өргөжүүлэх талаар санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, чадавхи бэхжүүлэх сургалтад хамрагдах</p>	<p>ХНХЯ, СЗСҮТ, ТХН</p>	<p>2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар</p>

		Цаашид ХБИ-ийн хэрэгцээт туслах хэрэгсэл, протез ортопедийн хүртээмжийг сайжруулах, хэрэгцээт туслах технологи, тоног төхөөрөмжийг худалдан авч, засварлах үйлчилгээг өргөжүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулна.				
5.	Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсүүд (Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд)	ХХҮГ/Х-үүд ХБИ-дэд зориулсан нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээ, тусламж олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Тогтмол хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг оновчтой болгох санал дүгнэлт, зөвлөмж ирүүлэх, нийгмийн шинэ үйлчилгээг хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх сургалтад хамрагдах	ХНХЯ, ХХҮЕГ, Аймаг, дүүргийн ХХҮГ/Х-үүд	2020 оны 03-р сар - 2022 оны 12-р сар
6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв (ХБХСЗХТ)	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх оношлох, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн хамт сэргээн засах, сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэн ажилладаг.	Хамтын ажиллагаа (дунд зэрэг)	Зөвлөгөөн: Хөгжлийн бэрхшээлийн олон улсын үйлдлийн ангилал /ICF/-ын талаарх мэдээлэл солилцооны хурал уулзалт, сургалтад оролцох, аргачлалыг оношилгоонд нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх	ХНХЯ, ТХН, ХБХСЗХТ	2019 оны 12-р сар - 2022 оны 12-р сар
7.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (ЭХМК)	ЭХМК нь хөгжлийн бэрхшээлийн олон улсын үйлдлийн ангилал /ICF/-ын талаар бүрэн зөв ойлголттой болж, тус аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай.	Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)	Зөвлөгөөн: ЭХМК-ийн гишүүдийг хамарсан хөгжлийн бэрхшээлийн олон улсын үйлдлийн ангилал /ICF/-ын талаарх мэдээлэл солилцооны хурал уулзалт, сургалтуудыг зохион байгуулах	ХНХЯ, ЭМЯ ЭХМК, ТХН	2020 оны 01-р сар - 2022 оны 12-р сар

8.	Хэвлэл мэдээлэл	Хэвлэл мэдээлэл нь ХБИ-ийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр түгээх, сурталчлан таниулах, олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх гол арга хэрэгсэл болно.	Мэдээлэл солилцоо (дунд зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтарч олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлан таниулах хурал, уулзалт зохион байгуулах, сонгогдсон хэвлэл мэдээллийн байгууллагуудад сургалт семинар зохион байгуулах	ХНХЯ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн байгууллагууд Д ТХН	2019 оны 01-р сар - 2022 оны 12-р сар
9.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд (ХБИБ)	ХБИБ-ын оролцоо нь хөгжлийн бэрхшээлийн талаар сурталчлан таниулах, олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх компани ажлын загвар боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Зөвлөгөөн: Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хурал, уулзалт, зөвлөгөөн болон хэвлэл мэдээллийн компани ажилд хамтран оролцох	ХНХЯ, ХБИБ, ТХН	2019 оны 01-р сар - 2022 оны 12-р сар
10.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)	ХБИ нь хөгжлийн бэрхшээлийн талаар сурталчлан таниулах, олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх арга хэмжээний үр шим хүртэгч гол бүлэг юм.	Зөвлөгөөн (өндөр зэрэг)	Мэдээлэл, зөвлөгөөн: Нийгмийн халамжийн шинэчлэлийн талаарх хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцох, санал хүсэлт, зөвлөмжийг ирүүлэх	ХНХЯ, ТХН	2019 оны 01-р сар - 2022 оны 12-р сар

Тайлбар: Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төслөөс санхүүгийн дэмжлэг олгохгүй.